



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/87

Ховд

Комисс байгуулах тухай

Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар баталсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 4 дүгээр бүлгийн 4.7.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа архивын баримтанд тооллого хийх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Отгонцэцэг -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд: Б.Энхмандал -Засаг даргын Тамгын газрын туслах нягтлан бодогч

Б.Батцэцэг -Архивын тасгийн сан хөмрөгийн эрхлэгч

Т.Наранчимэг -Архивын тасгийн архивч

Нарийн бичгийн дарга: П.Долгор -Аймгийн Засаг даргын Тамгын газрын архив-бичиг хэргийн эрхлэгч

2.Тооллогыг 2019 оны 06 дугаар сарын 03-наас эхлэн ажлын 5 хоногт багтаан явуулж дүнг танилцуулахыг комиссын дарга /Б.Отгонцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД